

**“БАЯН-АЛДАР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2018 оны 12 дугаар сар 18

Дугаар 08

Улаанбаатар хот

**ХУВЬЦАА ЭЗЭШИГЧДИЙН ЭРХИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ,  
ХУВЬЦААНЫ ҮНИЙГ ТОГТООХ,  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИДЭД МЭДЭЭЛЭХ ТУХАЙ**

Монгол улсын Компанийн тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1.1, 53.5, 54 дүгээр зүйлийн 54.1, 54.2, 54.3, 55-р зүйлийн 55.8 Санхүүгийн Зохицуулах хорооны 2016 оны 244 тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдын хурлын зар хүргэх журам”, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 374 тоот тогтоол, Төлөөлөн Удирдах зөвлөлийн гишүүдийн саналыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийг өөрчлөн байгуулсантай холбогдсон хувьцаа эзэмшигчдийн эрхийг хууль журмын дагуу хэрэгжүүлэхийг өөрчлөн байгуулах комисст үүрэг болгосугай.
2. “Баян-Алдар” ХК-ийн хувьцаа эзэмшигчид өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхийг 2018 оны 12 дугаар сарын 24-ний өдрөөс хэрэгжүүлж эхлэн 2019 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн 18:00 цагт дуусгавар болгосугай.
3. “Баян-Алдар” ХК нь хувьцаа эзэмшигчдийн шаардлагыг хэрэгжүүлж эргүүлэн худалдан авах хувьцааны үнийг Монголын хөрөнгийн биржийн сүүлийн 6-н сарын жигнэсэн дундаж ханшийг үндэслэн 642 /Зургаан зуун дөчин хоёр/ төгрөгөөр тогтоосугай.
4. Компани хувьцаа эзэмшигчдийн шаардлагыг хэрэгжүүлж эргүүлэн худалдан авах хувьцааны үнийг “Хувьцаа эзэмшигчдийн эрх, түүнийг хэрэгжүүлэх журам”-д тусган хавсралт 1-ээр, “Мэдэгдэл”-ийг хавсралт 2-оор тус тус баталсугай.
5. “Өөрчлөн байгуулах комисс” нь “Шаардах хуудас”-ыг Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Аризона төв, 12 тоот хаягаар хүлээн авсугай.
6. “Баян-Алдар” ХК нь “Монгорүматрикс ББСБ” ХХК-тай нэгдсэнээр цаашид компанийн үйл ажиллагаа өөрчлөгдөн санхүүгийн салбарт үйл ажиллагаагаа явуулах болсонтой холбогдуулан гүйцэтгэх захирал Б.Бадамцэцэгийг үүрэгт ажлаас нь чөлөөлж “Монгорүматрикс Гинко ББСБ” ХХК-ийн гүйцэтгэх захирал Б.Золжаргалыг нэгдсэн компани болох “Баян-Алдар ББСБ” ХК-ийн гүйцэтгэх захирлаар томилсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ч.ЧИНЗОРИГ